

АЗИЙН ОРНУУД БА
ШИНЭТГЭЛ

СОЛОНГОС-МОНГОЛЫН ЭДИЙН
ЗАСАГ, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
ХЭТИЙН ТӨЛӨВ

Ким Сү Ён (Соганы их сургуулийн
профессор)

1. Оршил

Чингис хааны эзэнт гүрэн мөхөснөөс хойш солонгосчууд, монголчуудын хооронд харилцаа төдийлөн байсангүй. Харин 1990 оны 3-р сард БНСУ, БНМАУ хоёр дипломат харилцаатай болжээ. Хоёр орны улс төрийн бодлогод нэгэн зэрэг ихээхэн өөрчлөлт орсноос ийм нөхцөл бололцоо бүрдэв.

Ро Дэ У-гийн Засгийн газраас явуулсан Умардын бодлого нь Солонгос социалист орнуудын эдийн засаг, улс төрийн харилцааны шинэ үеийг нээсэн билээ. Уг бодлогын дагуу Солонгос нь ЗХУ, Зүүн Европын орнуудтай дипломат харилцаа тогтоож, тэрээр социалист орнуудтай эдийн засгийн харилцаагаа эрчимтэй өргөжүүлж байна. Азийн социалист орнуудаас Монголтой эдийн засаг, улс төрийн харилцаа тогтоохыг Солонгос улс эрмэлзэж ирсэн билээ.

1980-аад онд ЗХУ, Зүүн Европын орнуудад эдийн засгийн өөрчлөлт Шинэчлэлт өрнөж, энэ нь Монголд нөлөөлөв. Монголоос гадаад орнуудтай явуулах бодлого нь урьд өмнө ЗХУ, ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудаар л хязгаарлагдаж байжээ. Гэвч ЗХУ-д эдийн засгийн шинэчлэлт явагдаж, ЗХУ-аас үзүүлэх тусламжийн хэмжээ багассанаас улс орныхоо эдийн засгийг нээлттэй болгож, зах зээлийн системд шилжих нь тус орны эдийн засгийн хөгжилд зайлшгүй чухал болохыг монголын удирдагчид мэдрэх болов. Түүгээр ч үл барам солонгосын эдийн засгийн хөгжлийн туршлагыг загвар болгож хэрэгжүүлэхээр болов.

Дипломат харилцаа тогтсоноос хойш 1 жилийн дотор хоёр орны хооронд төлөөлөгч болон бараа таваарын солилцоо идэвхтэй явагдаж ирэв. Түнш орноо судлах, харилцан ашигтай харилцаа тогтоох боломжийг эрж хайхын тулд хоёр орны бизнесмен, засгийн газрын албан ёсны төлөөлөгчид, эрдэмтэд оюутнууд харилцан айлчиллаа.

Уг илтгэлийн гол зорилго нь хоёр орны эдийн засгийн харилцааны сүүлийн үеийн байдлыг харуулж, энэхүү харилцан ашигтай харилцааны хэтийн төлөвийг тодруулахад оршино.

2. Хоёр талын эдийн засгийн харилцаа

1990 онд Солонгосоос Монголд гаргасан экспортын хэмжээ зөвхөн 515 мянган доллартай тэнцэж байгаа боловч энэ нь өмнөх жилийн үзүүлэлтээс 267 % -иар их байна. Монголоос Солонгост оруулж буй импорт нь 1990 онд 2 сая 191 мянган долларт хүрсэн нь түрүү жилийн үзүүлэлтээс 373 % -иар илүү байна, 1-р хүснэгтээс үзэхэд 1990 онд 2 талын гадаад худалдааны нийт эргэлт 2 сая 706 мянган доллартай тэнцэж байгаа нь Солонгосоос умардын орнуудтай хийж буй гадаад худалдааны эргэлтийн 0,05 %-г эзэлж байна. Мөн хүснэгтээс үзэхэд 1990 онд Солонгос-Монголын гадаад худалдааны хэмжээний өсөлт нь бусад Умард зүгийн орнуудтай хийсэн гадаад худалдааны үзүүлэлтээс хамаагүй илүү байна.

* Монгол, Өмнөд Солонгосын эрдэмтдийн анхдугаар бага хурал (1991. VI. 25-26) дээр тавьсан илтгэл

Хүснэгт № 1

Солонгосоос Монгол ба Умардын бусад орнуудтай
хийж буй худалдаа

		сая дол., %		
		1988	1990	%-ийн өөрчлөлт
Монгол	Экспорт	0,140	0,515	267,4
	Импорт	0,463	2,191	373,1
	Нийт	0,603	2,706	348,8
Хятад	Экспорт	1,438	1,553	8,0
	Импорт	1,705	2,268	33,0
	Нийт	3,143	3,821	21,6
ЗХУ	Экспорт	208	519	149,5
	Импорт	392	370	-5,6
	Нийт	600	889	48,2
Зүүн Европ ¹	Экспорт	270	541	100,4
	Импорт	117	213	82,1
	Нийт	387	754	94,8
Бусад ²	Экспорт	46	117	154,8
	Импорт	46	33	-22,8
	Нийт	92	150	63,0
Умардын Бусад орнууд	Экспорт	1,962	2,731	39,0
	Импорт	2,261	2,886	27,6
	Нийт	4,223	5,67	33,0

1. Югослав, Зүүн Герман, Польш, Чехословак, Унгар, Румын, Болгар

2. Вьетнам, Лаос, Камбож

Эдийн засгийн Төлөвлөлтийн удирдах газар, Эдийн засгийн мэдээ, 1991 оны 3-р сар.

Солонгосоос Умардын орнуудад оруулах шууд хөрөнгө оруулалт эрчимтэй өсч байна. Солонгосын Олон улсын эдийн засгийн хувийн аж ахуйн асуудлаарх зөвлөл (IPESK)-ийн мэдээгээр 1990 оны сүүлээр социалист орнуудад хэрэгжүүлж буй 74 төсөлд солонгосоос нийтдээ 182 сая долларын шууд хөрөнгө оруулжээ. Монголтой хамтарсан үйлдвэр байгуулах боломжийг судлах зорилгоор солонгосын бизнесменууд удаа дараа Монголд айлчилсан хэдий боловч шууд хөрөнгө оруулалт оруулах төсөл хараахан байхгүй байна. Харин Солонгосын засгийн газраас Монголд буцалтгүй тусламж болгож мянган тонн цагаан будаа, компьютер зэрэг зүйлийг өгсөн билээ.

1991 оны 3-р сард Монголын өндөр тушаалын 30-аад хүн Солонгост 1 сар болж, Солонгосын эдийн засаг, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийг судлав. Солонгос-Монголын эдийн засгийн хамтын ажиллагааны зөвлөлөөс Монголын 170 ажилчинг Солонгосын пүүсүүдэд техникийн дадлага хийлгэхээр төлөвлөж байна.

1991 оны 3-р сард Монголын ГХЯ-ны сайд Сеулд айлчлав. Солон

госын талтай уулзаад тэрээр хэлэхдээ Монгол нь зах зээлийн эдийн засагт шилжих зорилт тавьж гадаадын хөрөнгө оруулалтыг урамшуулах зорилгоор засгийн газраас эдийн засгийн онцгой бүс байгуулахаар төлөвлөж байгаа гэжээ. Хоёр орны ГЯЯ-ны сайд нар эдийн засаг, соёлын салбарт хамтран ажиллах талаар 4 хэлэлцээрт гарын үсэг зурав. Энэ нь эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн салбарт хамтран ажиллах худалдаа хөрөнгө оруулалтыг харилцан дэмжих, соёлын хамтын ажиллагааг хамарч байна. Хэлэлцээрийн дагуу Солонгос, Монгол хоёр орон нь гадаад худалдаа, хөрөнгө оруулалтад харилцан нэн тааламжтай нөхцөл олгох ажээ.

1990 оны 8-р сард Солонгосын солилцооны банк (КЕВ) нь БНМАУ-ын Банктай хэлэлцээр байгуулснаар Солонгосын худалдааныхан экспорт, импортын асуудлаар КЕВ-тай шууд харилцах замыг нээж өгжээ.

3. Солонгос-Монголын бараа солилцооны хэтийн төлөв

Солонгосын барааг гаргахад Монголын зах зээл нь Солонгосын бусад түнш социалист орнуудын дотор хамгийн бага юм. Монголын хүн ам дөнгөж 2 сая. Газар зүйн хувьд Монголтой харьцахад Хятад юм уу, Зөвлөлтөөр дамжина. Иймээс Солонгосоос Монголд бараа гаргахад эхлээд Хятадын усан боомт хүртэл ачиж, дараа нь 2000 шахам км төмөр замаар зөөнө.

Эдгээр хүчин зүйлс нь Солонгос, Монголын худалдааны өсөлтөнд сөрөг нөлөө үзүүлэх гол зүйл биш юм. Хамгийн чухал хүчин зүйл нь гадаад харилцааны талаар Монголын баримтлах бодлого юм. Хэрэв засгийн газар нь улс орныхоо эдийн засгийг хөгжүүлэхийн тулд зах зээлийн эдийн засаг хөгжсөн орнуудтай харилцаагаа өргөжүүлэх бодлого явуулах юм бол, худалдааны хэмжээ, экспорт ч, импорт ч өсөх нь дамжиггүй. Монголын экспорт, импортын өсөлт тэнцвэртэй байвал валют дутах, гадаад худалдаа алдагдалд орох зэрэг хурц асуудал гарахгүй.

1991 оны 2-р сард Монгол улс Олон улсын валютын фондын 155 дахь, Азийн хөгжлийн банкны 50 дахь гишүүн болов. Эдгээр санхүү хөгжлийн, олон улсын байгууллагад элссэнээр Монгол нь хөнгөлттэй нөхцлөөр зээл авах боломжтой болж байна. Экспортын бараа үйлдвэрлэх салбарыг хөгжүүлэх, нийгмийн дэд бүтцэд зориулсан хөрөнгийг өсгөх зэрэг хөгжлийн төсөл нь олон улсын байгууллагуудын тусламжаар хэрэгжих юм. Олон улсын байгууллагуудад элсэж, хөгжингүй орнуудтай эдийн засгийн харилцааг хөгжүүлснээр Монголд үзүүлэх эдийн засгийн тусламжийн хэмжээ ч өснө.

Үйлдвэрлэлийн төвшин дорой байгаа Монголын нөхцөлд хөдөлмөр болон хөрөнгө оруулалт ихээхэн шаардагдахгүй анхдагч болон хагас боловсруулсан бүтээгдэхүүн экспортын салбарыг хөгжүүлэх шаардлагатай. Монгол нь нүүрс, молибден, зэс зэрэг түүхий эдээр баялаг. Гэтэл Солонгос нь жилд түлшнээс гадна 10 тэрбум долларын түүхий эд гадаадаас оруулж байна. Хэрэв Солонгосын худалдааны пүүсүүд Монголоос тасралтгүй, тааламжтай нөхцлөөр түүхий эд авах боломж бүрдвэл Солонгос Монголын худалдаа үлэмж өснө. Жишээ нь 1990 онд Монголоос Солонгосд оруулсан барааны ихэнхийг ноос, зэс, төмөр зэрэг аж үйлдвэрийн түүхий эд эзэлж байна.

Солонгосоос Монголд 1990 онд ихэвчлэн ганц хэрэглэдэг тариур, компьютер зэрэг аж үйлдвэрийн бараа гаргасан байна. Монголд экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх салбар, дэд бүтцийг хөгжүүлэхэд машин, тоног төхөөрөмж шаардлагатай байна. Түүнээс гадна жил бүр их хэмжээний өргөн хэрэглээний бараа гадаадаас авч байна. Гэтэл Солонгос нь эдгээр бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр дэлхийн хамгийн тэргүүний технологи нэвтрүүлж дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар-

тай болжээ. Эдгээр барааг Монголд гаргахад газар зүйн талаар ч Япон, Америк, Европын орнуудаас илүү давуу талтай.

Энэ оны 3-р сард Хюндэ Мотор (Hyundai Motor Co) пүүс Монголд 30 суудлын машин оруулав. Энэ жил нийтдээ 330 машин экспортлохоор төлөвлөж байна. Мөн Дэү нэгтгэл (Daewoo corporation) 30 сая долларын харилцаа холбооны төхөөрөмжийг Монголд нийлүүлэхээр хэлэлцээр хийж байна. Тус пүүс нь Монголд 7000 ширхэг хөргөгч гаргасан байна. Үүнийг Дэү Электроникс (Daewoo Electronics), Хятадын 2 пүүстэй 1988 онд байгуулсан хамтарсан үйлдвэрт үйлдвэрлэсэн юм. Солонгос, Монголын бараа солилцоо нь гадаад худалдааны талаар Монголын баримтлах байр сууринаас шалтгаална. Гадаад худалдааны салбар засгийн газрын монопольд байх нөхцөлд уг салбарын өсөлт эрчимтэй байж чадахгүй. Экспортын бараа үйлдвэрлэгчид гадагшаа бараагаа гарган, экспортоо өсгөх талаар тодорхой санаачилга гаргах ёстой. Экспортын хэмжээг өсгөх зорилт тавьж байгаа эхний шатанд энэ нь зайлшгүй чухал юм. Тус орны гадаад худалдааг гадаад худалдааны байгууллагуудын хүнд сурталтнууд явуулж буй нөхцөлд гадаадын худалдан авагчийн таалал сонирхлоор явагдаж, дотоодын үйлдвэрлэгчид экспортын үйлдвэрлэлийг өсгөх талаар, ямар ч нөлөөгүй байдал үргэлжлэх болно. Гадаад худалдааг социалист орнуудтай явуулах нөхцөлд тус салбар нь улсын мэдэлд байж болох юм. Харин зах зээлийн харилцаатай орнуудтай гадаад худалдааны харилцаагаа өргөжүүлэхийн тулд гадаад худалдаа, дотоодын үйлдвэрлэлийн хоорондох үр ашигтай хязгаарлалтыг арилгах шаардлагатай.

1987 оноос Монголд үйлдвэрлэлийн санаачлагыг дээшлүүлэх, гадаад худалдаа, хөрөнгө оруулалтыг чөлөөтэй болгоход чиглэсэн зарим арга хэмжээ авав. Капиталист орнуудтай харилцаагаа хөгжүүлж, түүний үр шимийг хүртэе гэвэл Монгол нь эдгээр арга хэмжээг улам гүнзгийрүүлэх ёстой.

4. Солонгосын шууд хөрөнгө оруулалт, эдийн засгийн . тусламжийн хэтийн төлөв

Сүүлийн жилүүдэд Солонгосын пүүсүүд гадаад орнуудад үйлдвэрлэлийн салбаруудаа байгуулж байна. Солонгосын шууд хөрөнгө оруулалт нь хөгжингүй, хөгжиж буй орнууд гэсэн 2 чиглэлээр явагдаж байна. Хөгжиж буй орнууд хөрөнгө оруулахдаа түүхий эд боловсруулах, хөдөлмөрийн багтаамж ихтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх салбаруудыг их анхаарч байна.

Монгол 2-хон сая хүн амтай. Иймээс Монголын ажиллах хүчийг ашиглах, дотоодын зах зээл рүү нэвтрэх нь гол зорилт биш. Харин байгалийн түүхий эдийг ашиглах, боловсруулах салбарт шууд хөрөнгө оруулах нь ашигтай байх талтай. Солонгос түүхий эдийг гадаадаас авдаг учир зах зээл хайх шаардлагагүй болох юм.

1991 оны 4-р сард социалист орнуудад оруулах шууд хөрөнгө оруулалтыг өсгөхийн тулд солонгосын засгийн газраас хөрөнгө оруулалтын ажиллагааг хялбарчлах арга хэмжээ авав. Умардың орнуудад засгийн газрын хяналтгүйгээр оруулж болох хөрөнгийн дээд хэмжээг 1-сая доллараас 2 сая хүртэл өсгөв.

Одоо 2 сая доллараас доош хөрөнгө социалист орнуудад оруулахад Солонгосын Банкны (Bank of Korea) зөвшөөрөл байвал болох ажээ. Монголын эдийн засаг нь ЗХУ-ын тусламж багассанаас хүнд бэрхшээлтэй тулгарч байна. Одоо тус орон гадаадаас удаан хугацааны зээл, шууд хөрөнгө авах шаардлагатай. Монголын засгийн газар нь гадаадын хөрөнгө оруулалтыг урамшуулах зорилгоор эдийн засгийн онцгой бүс байгуулах асуудлыг судалж байна.

Солонгос-Монголын харилцаа, эдийн засгийн бодлогын сүүлийн үеийн хөгжлийн байдлыг харахад, Монголд Солонгос-Монголын хамтарсан үйлдвэр байгуулахад тийм ч удаан хугацаа шаардагдахгүй. Гэхдээ юуны түрүүнд хоёр талын худалдааны харилцааг өргөжүүлж хүмүүсийг уулзуулж, бодол солилцох боломж олгож, дараа нь хөрөнгө оруулах асуудлыг ярих нь зүйтэй.

Солонгосын засгийн газар Монголд албан ёсны тусламж үзүүлбэл Монголтой явуулах худалдаа, хөрөнгө оруулалт улам хялбар болох нь дамжиггүй. Хөгжиж буй орнуудад Солонгосоос үзүүлж буй эдийн засгийн тусламж нь Япон, АНУ зэрэг хөгжингүй орнуудаас үлэмж бага юм. Гэвч дараагийн хэдэн жил Солонгосын засгийн газар нь тусламжийн хэмжээг нилээн өсгөхөөр төлөвлөж байна. 1990 онд Солонгосын албан ёсны хөгжлийн тусламж 89 сая долларт хүрэв. Одоо 100-гаад хөгжиж буй орнууд Солонгосоос техникийн болон буцалтгүй тусламж авч байна. Сүүлийн үед урт хугацааны концесси Зээл, эдийн засгийн хөгжил, хамтын ажиллагааны фондын зээл нь тусламжийн чухал суваг болж байна. Гэвч эдийн засгийн хөгжил, хамтын ажиллагааны фондын зээл нь цөөн хэдхэн орнуудад л чиглэгдэж байна.

Монголын хөгжлийн өнөөгийн шатанд Монголын мэргэжилтэн, оюутнуудыг Солонгост илгээж, үйлдвэрлэлийн төрөл бүрийн салбарт солонгосын мэргэжилтнүүдийг ажиллуулах зэрэг хэлбэрээр техникийн тусламж үзүүлэх нь чухал байна.

5. Дүгнэлт

Монгол улс эдийн засгийнхаа өөрчлөлт шинэчлэлтийг амжилттай явуулбал Солонгос-Монголын эдийн засгийн харилцаа өргөжиж, үр шимээ өгөх болно. Монгол болон бусад социалист орнуудад хэрэгжүүлж буй эдийн засгийн өөрчлөлт шинэчлэлт нь зөвхөн өөрийн орны эдийн засгийн үйл ажиллагааг чөлөөт зах зээлийн харилцаанд оруулах зорилгоор тавьж байгаа биш юм. Эдгээр өөрчлөлтийн мөн чанар нь зогсонги байдалд орсон социалист системийн эдийн засгийг хөгжингүй болон шинээр аж үйлдвэржсэн орнуудын зах зээлийн эрчимт хөгжил бүхий засгийн харилцаатай холбоход оршино.

Сүүлийн хэдэн арван жилийн туршлагаас үзэхэд эдийн засгаа социалист маягаар удирдаж зөвхөн социалист орнуудын хүрээнд харилцаагаа өргөжүүлж, капиталист орнуудтай хязгаарлагдмал харилцаатай байснаар социалист орнуудын эдийн засгийн байдал ард түмний хүсч хүлээж байгаа түвшинд хүрээгүй юм.

Тэргүүний технологийг нэвтрүүлж, эрчимтэй хөгжиж буй капиталист орнуудтай эдийн засгийн харилцаа холбоогоо бэхжүүлснээр л социалист эдийн засаг найдвартай хөгжих нь гарцаагүйг социалист орнуудын удирдагчид ухаарах болов.

Монголын өөрчлөлт шинэчлэлт амжилттай явагдах эсэх нь Монголын ард түмэн өөрчлөлт шинэчлэлтийн шаардлагыг хэрхэн ойлгосноос шалтгаална. Монголын өөрчлөн байгуулалт амжилтанд хүрч, тус орны эдийн засаг эрчимтэй өсөх нь Солонгосд ч ашигтай. Монгол улстай худалдаа болон эдийн засгийн олон хэлбэрийн харилцааг хөгжүүлэх нь Солонгосоос Монгол улсад үзүүлэх хамгийн чухал тусламж болно гэдэгт солонгосчууд итгэж байна.